



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар A/25

Мандалговь

**“Хайр өвтгөдөггүй”
аян зохион байгуулах тухай**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, Монгол Улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэл түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хайр өвтгөдөггүй” сарын аянг зохион байгуулсугай.

2. “Хайр өвтгөдөггүй” аян зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 264.000 (Хоёр зуун жаран дөрвөн мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА  Ц.ГАНЗОРИГ



43119067